



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн  
20 тоот Тогтоолын Хавсралт

**ИНВЕСКОР ББСБ-ЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО**

**IC-83 V-2.0**

**2022 он**

|  |   |
|--|---|
| <i>Хамрах хүрээ:</i><br>ИНВЕСКОР ББСБ ХК, түүний охин компаниуд                          | <i>Хариуцах эзэн:</i><br>ИНВЕСКОР ББСБ<br>Хууль, Эрсдэлийн удирдлагын газар       |
| <i>Хувийг хадгалах:</i><br>Төлөөлөн удирдах зөвлөл,<br>Хууль, эрсдэлийн удирдлагын газар | <i>Танилцах:</i><br>ИНВЕСКОР ББСБ ХК болон түүний охин компаниудын нийт ажилтнууд |
| <i>Хүчинтэй хугацаа:</i><br>2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн                       | <i>Хуудасны тоо:</i><br>4 хуудас  |
| <i>Дараагийн үнэлгээ хийх огноо:</i><br>2023 оны 06 сарын 22-ны өдөр                     |   |
| <i>Журмын дугаар:</i>  | <i>Хувилбар:</i><br>V-2.0   |

### Өөрчлөлтийн түүх

| #  | Хувилбар | Өөрчлөлт хийгдсэн огноо | Өөрчлөлтийн агуулга   |
|----|----------|-------------------------|---|
| 1. | 1.0      | 2021.03.30              | Монголын улсын тогтвортой санхүүжилтийн зарчмуудтай уялдуулан анхлан боловсруулав.                |
| 2. | 2.0      | 2022.06.22              | Компанийн засаглалын кодексын шинэчлэлтэд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулав. |
| 3. |          |                         |   |
| 4. |          |                         |   |
| 5. |          |                         |   |

**АГУУЛГА**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....1
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД.....1
3. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ .2

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого (цаашид Бодлого гэх)-ын зорилго нь “Инвескор ББСБ” ХК болон түүний охин компаниудын (цаашид хамтад нь ББСБ гэх)-ийн бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг хангах үүргийн хүрээнд баримтлах зарчмууд болон үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

## 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

2.1. ББСБ нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд дараах зарчмуудыг баримтлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

2.1.1. **Байгаль орчноо хамгаалах** - Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

2.1.2. **Хүний эрх, нийгмийг хамгаалах** - Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

2.1.3. **Соёлын өвийг хамгаалах** - Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палеонтологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

2.1.4. **“Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих** - Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.1.5. **Санхүүгийн хүртээмжийг дэмжих** - Бид жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал нийгмийн бүлгүүдэд

зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, урамшуулах арга замыг хэрэгжүүлнэ.

- 2.1.6. **Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих** - Бид хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.
- 2.1.7. **Ил тод байдал, хариуцлагыг дэмжих** - Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.
- 2.1.8. **Манлайлан үлгэрлэх** - Бид харилцагчдадаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

### **3. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ**

- 3.1. ББСБ-н нэгжүүд нь байгаль, орчин нийгмийн хариуцлагын зарчмуудыг доорх байдлаар мөрдөж хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 3.1.1. **Гүйцэтгэх удирдлага** – Байгаль, орчин нийгмийн хариуцлагын хүрээнд баримтлах бодлогыг ББСБ-ын бизнес төлөвлөгөө болон стратеги төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Компанийн засаглалын зүй зохистой зарчмуудыг өдөр тутам хэрэгжүүлж, олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар ажиллана.
  - 3.1.2. **Хууль, Эрсдэлийн удирдлагын газар** - ББСБ-ын нэгжүүд байгаль орчин, нийгмийн хариуцлагын зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн дагаж мөрдөж буйд хяналт тавих ба байгаль орчин нийгмийн хариуцлагын хүрээнд баримтлах бодлогыг тогтмол шинэчилж сайжруулна.
  - 3.1.3. **Салбарын удирдлагын газар, салбарууд** – ББСБ-ын зээлийн бодлого, журмуудын дагуу байгаль орчин, нийгэмд хор хөнөөлтэй бизнесийг санхүүжүүлэхгүй бөгөөд байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө бүхий аливаа үйл

ажиллагааг дэмжиж ажиллана. Чанарын удирдлага болон харилцагчийн үйлчилгээний олон улсын стандартуудыг нэвтрүүлэх замаар харилцагчийн эрх ашгийг дээдэлж ажиллана.

- 3.1.4. **Хүний нөөцийн газар** – Хүний нөөцийн бодлого болон холбогдох журмуудын дагуу ажилтны эрх ашгийг сахин хамгаалж эрх тэгш байдал, шударга харилцааны зарчмуудыг хадгалж хамгаална. Соёлын өвийг хамгаалах, манлайлан үлгэрлэх чиглэлээр ББСБ-ын ажилтнуудад зориулсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.1.5. **Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газар** – Ногоон бизнес болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор уян хатан нөхцөлтэй, зардал багатай эх үүсвэрийг бүрдүүлж ажиллана.
- 3.1.6. **Санхүү бүртгэл, тайлагналын газар** – ББСБ-ын санхүү бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын стандарт, дотоодын хууль журамд заасны дагуу зохион байгуулна. Худалдан авалт болон зээл олголтын үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчилгүй, дотоод дүрэм журмын дагуу гүйцэтгэнэ.
- 3.1.7. **Үйл ажиллагааны газар** – ББСБ-ын ус цахилгаан, цаасны хэрэглээг боломжтой бага түвшинд байлгаж, худалдан авалт болон хамтран ажиллах түншүүдээ сонгохдоо байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг нь харгалзан үзнэ.
- 3.1.8. **Бизнес хөгжлийн газар** – Финтект суурилсан цахим шийдлүүдийг хөгжүүлж харилцагч нарт санал болгох замаар цаг хугацаа, зардлыг нь хэмнэж өгнө. Ногоон зээлийн бизнесийг дэмжсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг нэвтрүүлж хөгжүүлнэ.
- 3.1.9. **Бизнесийн харилцаа хамтын ажиллагааны газар** - ББСБ нь ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлөөр харилцагчдад санал болгоно. Мөн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарсан санхүүжилт, батлан даалт, сургалт зөвлөгөөний үйл ажиллагааг байнга зохион байгуулна.
- 3.1.10. **Маркетинг, олон нийттэй харилцах газар** – Байгаль, орчин нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй ажлуудаа таниулан сурталчлах, олон

нийттэй харилцах, нийгэм эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой сургалт, зөвлөгөө, эерэг мессежнүүдийг түгээнэ.

3.1.11. **Дотоод аудитын газар** – ББСБ-ийн бүхий л түвшний үйл ажиллагаанд хяналт тавьж, эрсдэлийн удирдлага, хянан нийцүүлэлт, засаглалын зохистой байдлыг хараат бусаар үнэлж дүгнэнэ. Олон улсын стандарт, дотоодын хууль журмын дагуу бизнесийн болон арын албаны хяналтын тогтолцоо, процессыг байнга сайжруулж хөгжүүлэхэд заавар зөвлөмжөөр хангаж ажиллана.

--ooOoo--

